



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.28 № 447

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Лхагважавын Батмөнхийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Audit(D)Дүгнэлт/2024

0130 0039

Дүгнэлт

Лхагважавын Батмөнхийн /РД:ИИ67101016/ Орон нутгийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Л.Батмөнхийн мөрийн хөтөлбөр (4 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Л.Батмөнхөд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

**ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ СУМЫН 2-р ТОЙРОГТ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Л.БАТМӨНХИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Эрхэм зорилго: Сум орон нутгийнхаа өнгө үзэмжийг сайжруулах, хөрөнгө оруулалт, тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээг өргөтгөх, ард иргэд, малчдынхаа амьдралын түвшинг дээшлүүлэх, Нөмрөг сумаа хөгжүүлэхэд чиглэгдэнэ

Хөтөлбөрийн зорилго:

Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын хүрээнд сум, багийнхаа хүн ардын хөгжлийн бодлого үйл ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр иргэн бүрийн нийгмийн идэвхийг дээшлүүлэхэд анхаарч сумын хөгжилд оруулах оролцоог нэмэгдүүлж төрийн болон хувийн хэвшилд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

НЭГ. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл мэндийн бодлого

1.2.1 Иргэдийг эрт илрүүлгийн үзлэгт бүрэн хамруулах бодлого баримталж ажиллана.

1.2.2 Сумын иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар багийн эмч, эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарч ажиллана.

1.2. Боловсролын бодлого

1.2.3. Малчид, иргэдийнхээ сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулж сургууль завсардалт гаргахгүй байхад анхаарч ажиллана.

1.2.4 Сургалтын чанарыг дээшлүүлэх талаар сумын сургалтын байгууллагуудтай хамтарч ажиллах замаар сурлагын хоцрогдолтыг бууруулах бодлого баримтлана.

1.3. Соёл, спорт, аялал жуулчлалын бодлого

1.3.1 Сумынхаа байгалийн үзэсгэлэнт болон түүхэн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлалын маршрут гаргаж ажиллана.

1.3.2. Соёлын төвийн дэргэд хүүхэд залуучуудын дунд явагддаг урлагийн бүх төрлийн дугуйланд сурагчдыг хамруулж авъяас чадвараа нээн хөгжүүлэх үйлд чиглүүлнэ.

1.3.4. Орон нутаг судлах музей, соёлын үнэт зүйл, өвийг хадгалж хамгаалах ажилд иргэдийг оролцоог нэмэгдүүлнэ.

1.4. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого

1.4.1 Залуу малчин өрхүүдийг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулах, малын тоо толгойг нэмэгдүүлэх, хөдөлмөрөө хоршиж хоршоо, нөхөрлөл байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

1.4.2. Сум, багийнхаа малчдыг хямд өртөг бүхий малын ногоон тэжээлээр хангах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.4.3. Мал бүхий малчин иргэдийг тав тухтай өвөлжөө бууцаа хангах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуйн бодлого

2.1.1 Сум орон нутагтаа өндөр үржил шимтэй цөм сүргийг бий болгох ажлыг эхлүүлнэ.

2.1.2. Бэлчээрийн мал аж ахуйд голлон анхаарч булчээрийн даацыг судлах, улирал тутам ашиглах хуваарь тогтоох замаар нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна

2.1.3 Бүх төрлийн малын үүлдэр угсааг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх өндөр ашиг шимтэй хээлтүүлэгчээр сүргийг сэлбэх, малчдыг малаа тарга тэвээрэг авахуулах оторлох отрын бүс нутгийг зохион байгуулан ажиллана

2.1.4. Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг тогтмолжуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг дээшлүүлэх талаар мал эмнэлэгийн салбартай хамтарч ажиллана.

2.1.5 Сумын малчдын хадлангийн талбайн эзэмшилтийг сайжруулан өргөжүүлж, хашиж хамгаалж, ногоон тэжээл тариалалтыг нэмэгдүүлнэ

2.1.6. Бэлчээрийг хортон мэрэгчдээс хамгаалах арга хэмжээг дэмжиж жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж хамтарч ажиллана.

2.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого

2.2.1. Малчдын гар дээр байгаа малын түүхий эд ноос ноолуурыг нэгдсэн журмаар нэг цэгт төвлөрүүлж зах зээлд өндөр өртгөөр борлуулах бодлого баримтлана.

2.2.1 Малчдын өөрийн гараар хийсэн цагаан идээг зах зээлд борлуулах "Шинэ сар" үзэсгэлэн гаргана.

2.4. Төсөв санхүүгийн чиглэлээр

2.4.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсвийн өргүй ажиллах боломжид анхаарах.

2.4.2 Орон нутгийн төсвийг үргүй зардал гаргуулахгүй байх тал дээр анхаарч хяналт тавьж ажиллана.

2.4.3 Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын чанар гүйцэтгэлд хяналт тавина.

2.5. Байгаль орчны талаар хэрэгжүүлэх бодлого

2.5.1 Байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хөрс, ус, агаарын бохирдлоос сэргийлэх ажилд иргэдийг олноор хамруулж хяналт тавьж ажиллуулана.

2.5.2. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт шалгалтыг тогтмолжуулан хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох арга хэмжээнд идэвх санаачлагатай ажиллана.

2.5.3. Ойг хөнөөлт хортон шавьжнаас хамгаалах, нөхөн сэргээх ажилд санаачлага гаргаж холбогдох байгууллагад нь уламжилж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Орон нутгийн засаглалын ажил үйлчилгээ

3.1.1 Орон нутгийн эрх баригчдын ажил үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хариуцлагатай болгож, иргэн төрдөө итгэх итгэлийг бий болгосон засаглалыг бэхжүүлнэ.

3.1.2. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага ёс зүйд анхаарч ажиллана.

3.1.3. Цахим "Иргэний танхим"-ийн үйл ажиллагааг бий болгон, иргэдийн санал бодлыг байнга сонсож, төрийн үйлчилгээ, бодлого төлөвлөлтөнд тусгаж ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.1.4 Сумын иргэдэд байгалийн хүндрэл нүүрлэсэн цаг тухайд нь биечлэн очиж нөхцөл байдалтай танилцаж, дэмжлэг үзүүлж ажиллана.

3.1.5. Төрийн албан хаагчдын ажлын цаг баримтлах соёлыг дээшлүүлнэ.

3.2. Хүний эрхийг хангах, хууль, эрх зүйн ажил үйлчилгээ

3.2.1 Төрийн албан хаагчдын хүний эрхийг зөрчсөн хүнд сурталыг бууруулах бодлого баримталж ажиллана.

3.2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахин хамгаалахад иргэд хөдөлмөрчид, ард иргэдийг татан оролцуулах, малын хулгай болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.2.3. Согтууруулах ундаагаар үйлчилдэг ААНБ-ын өсвөр насны хүүхдэд үйлчилдэг байдлыг таслан зогсоох арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтарч хэрэгжүүлнэ.

3.2.4. Хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, цагдаагийн байгууллагын үйлчилгээг сайжруулах талаар хяналт тавьж ажиллана.

3.3. Гамшгаас хамгаалах бодлого


3.3.1. Байгалийн гамшиг гэнэтийн аюул ослоос үйдэлтэй эрсдэлийг бууруулахад урьдчилан сэргийлэх ажлыг байгаль орчны байцаагч нартай хамтарч хийнэ.

3.3.2 Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан үхэж үрэгдэж буй ан амьтадыг эрсдэлт нөхцлөөс хамгаалах арга хэмжээ авна.

3.3.3. Гамшиг осолтой тэмцэх чадавхийг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулахад ажлын явц үр дүнд хяналт тавьж ажиллана.

ТА ИТГЭ БИ ЗҮТГЭЕ

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  Л.БАТМӨНХ

